



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2020.07.17 № 498  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХЭНТИЙ  
АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА  
Н.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

### Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлага хангаагүй талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хэнтий аймгийн Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

#### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

#### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 – 1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

#### Дүгнэлт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хэнтий аймгийн Ардчилсан намын хорооны “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-т Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл,

003030625

сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн аудит хийхэд хуульд нийцээгүй, эдийн засгийн үндэслэл тооцоо судалгаагүй зорилт, арга хэмжээ тусгасан нь хууль тогтоомжийн холбогдох шаардлагад нийцсэн гэх дүгнэлт гаргах боломжгүй байна.

Энэхүү дүгнэлтийн нэгдүгээр хавсралтаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт нийцээгүй зорилт, арга хэмжээний жагсаалтыг, хоёрдугаар хавсралтаар “Алсын хараа-2050”-д нийцээгүй зорилт, арга хэмжээний жагсаалтыг, гуравдугаар хавсралтаар санхүүжилтийн эх үүсвэр, зардлын дүн шаардлагатай зорилт, арга хэмжээний жагсаалтыг хүргүүлэв.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар ирүүлэх боломжтой.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР